

**МОНГОЛ УЛСЫН ТӨВ БОЛОН БАРУУН БҮС НУТАГТ ШҮЛХИЙ ӨВЧИНТЭЙ
ТЭМЦЭХЭД ЯАРАЛТАЙ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ (ТСР/MON/3701) ТӨСЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2021.02.26

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл		
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	Монгол улсын төв болон баруун бүс нутагт шүлхий өвчинтэй тэмцэхэд яаралтай дэмжлэг үзүүлэх (ТСР/MON/3701)		
2	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБ ХХААБ		
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААБ, ХХААХҮЯ Хэрэгжих нийт хугацаа: 1 жил 9 сар		
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)		
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1: Одоогийн шүлхийтэй тэмцэх арга хэмжээнд үнэлгээ хийж, эрсдэлд суурилсан шүлхийтэй тэмцэх стратеги боловсруулах,</p> <p>Зорилт 2: Сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчдийг чадавхжуулах, шаардлагатай багаж хэрэгслээр хангах,</p> <p>Зорилт 3: Шүлхий өвчнөөс сэрэмжлүүлэх материал боловсруулж олон нийтэд хүргэх,</p> <p>Зорилт 4: Шүлхий өвчний үед хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх,</p> <p>Зорилт 5: Малын халдварт өвчний тархалтад шилжилт хөдөлгөөний үзүүлэх нөлөөг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох.</p>		
5	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Төслийн болон удирдлагын зардалд 2020 оны жилийн эцсийн байдлаар 74,241 ам.доллар зарцуулж, 90.7%-ийн биелэлттэйгээр санхүүжилтийг зарцуулсан байна.	
		Үүнд:	Төсөв (2020 он)	Гүйцэтгэл
	Багц 1	81,878	74,241	90.7%
	Нийт	81,878	74,241	90.7%
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ		
	<p>1-р зорилтын хүрээнд: Шүлхийтэй тэмцэх арга хэмжээнд үнэлгээ хийж, эрсдэлд суурилсан шүлхийтэй тэмцэх стратеги боловсруулах.</p> <p>Хүрэх үр дүн 1: Шүлхийтэй тэмцэх үйл ажиллагаа болон стратегид үнэлгээ хийх, Стандарт ажиллагааны зааврыг эцэслэн зүүн бүс дэх тархалтыг бууруулж төв, баруун бүсэд халдвар тархахаас сэргийлэх.</p>	<ul style="list-style-type: none"> Одоогийн шүлхийтэй тэмцэх арга хэмжээнд үнэлгээ хийж зөвлөмж боловсруулсан. Шүлхийтэй тэмцэх дунд хугацааны (2020-2023) стратегийн төсөл боловсруулсан. Шүлхий өвчин Монгол улсад тархах эрсдэлт хүчин зүйлсийн үнэлгээ хийсэн. Шүлхий өвчний үед дэгдэлтийн судалгааг хийх Стандарт ажиллагааны зааврын төслийг боловсруулсан. 		

<p>2-р зорилтын хүрээнд: Сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчдийг чадавхжуулах, шаардлагатай багаж хэрэгслээр хангах</p> <p>Хүрэх үр дүн 2: Мал эмнэлгийн шүлхийтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чадавх сайжирсан байна.</p>	<ul style="list-style-type: none"> • Нийт 19 аймгийн 295 сумын 359 сумын мал эмнэлгийн тасгийн тархвар зүйчдийг “Дэгдэлтийн судалгаа, био-хамгаалал” сургалтад хамруулсан. • 80.000 орчим ам.долларын өртөг бүхий мал эмнэлгийн багаж хэрэгслийг (шүлхийн түргэн тест, халдвар хамгааллын хувцас, малаас сорьц авах багаж, халдваргүйжүүлэх бодис гэх мэт) орон нутгийн мал эмнэлгийн байгууллагуудад хүргүүлэв. • Шүлхий өвчний дэгдэлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний үзүүлэх сургалтыг 2019 оны 10 дугаар сард зохион байгуулж Өмнөговь, Төв, Өвөрхангай, Дундговь аймгийн 75 малын эмч оролцсон. • Шүлхий өвчний үед сорьц авах, илгээх талаар 5 төрлийн видео хичээл боловсруулж МЭЕГ-ын цахим хуудсаар дамжуулан орон нутгийн малын эмч нарт хүргэсэн.
<p>3-р зорилтын хүрээнд: Шүлхий өвчнөөс сэрэмжлүүлэх материал боловсруулж олон нийтэд хүргэх</p> <p>Хүрэх үр дүн 3: Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн мэдлэг, ойлголт сайжирна.</p>	<ul style="list-style-type: none"> • Монголын Олон Нийтийн Радио Телевизтэй хамтран мал эмнэлгийн салбарт хийгдэж байгаа онцлох үйл ажиллагааны талаар “Эрүүл мал-Монголын баялаг” цуврал нэвтрүүлэг бэлтгэн, 12 сарын хугацаанд нийт 24 удаа нэвтрүүлэв. Мөн бэлтгэсэн нэвтрүүлгүүдийг МЭЕГ-ын Facebook хуудсанд байршуулсан. • Малчдад зориулсан шүлхийгээс сэрэмжлүүлэх 5 төрлийн анимейшин бэлтгэж, Малчин ТВ-гээр дамжуулан нийт 480 удаагийн цацалтаар олон нийтэд хүргэв.
<p>4-р зорилтын хүрээнд: Шүлхий өвчний үед хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх</p> <p>Хүрэх үр дүн 4: Одоогийн шүлхийтэй тэмцэх үйл ажиллагаа сайжирч, төв болон баруун бүсэд халдвар тархахаас сэргийлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • Шүлхий өвчин гарсан үед хорио цээрийн үйл ажиллагаанд хяналт тавих зориулалттай өндөр хүчин чадал бүхий 2 ширхэг дроныг (нисдэг камер) МЭЕГ-т хүлээлгэн өгөв.
<p>5-р зорилтын хүрээнд: Малын халдварт өвчний тархалтад шилжилт хөдөлгөөний үзүүлэх нөлөөг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох</p> <p>Хүрэх үр дүн 5: Малын шилжилт хөдөлгөөний хяналт, дархлаажуулалтын судалгаа, шүлхийтэй тэмцэх чиглэлээр хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох үйл ажиллагаа сайжирна.</p>	<ul style="list-style-type: none"> • Малын шилжилт хөдөлгөөн нь халдварт өвчний тархалтад хэрхэн нөлөөлдөг болохыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох зорилгоор Архангай аймгийн Хотонт сумын 6 малчны бог малд GPS хүзүүвч суурилуулж судалгааны ажил хэрэгжүүлэв. • Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор “Мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх төв”-ийн жишиг загвар, ажлын зураг, макетыг МЭЕГ хүлээлгэн өгсөн. • 2018-2019 онуудад хийгдсэн шүлхийн халдвар илрүүлэх тандалт болон дархлаажуулалтын дараах тандалтын үр дүнг хэлэлцэх уулзалт зохион байгуулав.

7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>1. Төслөөр бий болсон үр дүнг ашиглах, хүрсэн түвшинг тогтвортой хадгалах чиглэлд хэрэгжүүлэгч байгууллага болох МЭЕГ илүү анхаарал хандуулах /Зорилт 1/,</p> <p>2. Төслөөр бий болсон үр дүнг шийдвэр гаргагч, мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүд болон оролцогч бусад талууд ашиглах боломжийг бүрдүүлэх талаар учир дутагдалтай байна.</p> <p>Зөвлөмж</p> <p>1. Төслийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг тогтооход салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн оролцоог хангах, хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээ хийж хэвшүүлэх, төсвийг тухайн төслийн төсөвт тусгуулах чиглэлд Сангийн яамнаас нэгдсэн удирдамж, чиглэл шаардлагатай байна.</p> <p>2. Төслөөр бий болсон үр дүнг ашиглах, хүрсэн түвшинг тогтвортой хадгалах ажлыг хэрэгжүүлэхэд МЭЕГ илүү анхаарах, мөн судалгааны үр дүн, загварыг байгууллагын цахим хуудас зэрэгт нээлтэй байршуулж, ашиг хүртэгчдийн ашиглах боломжийг нэмэгдүүлэх</p>						
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Хангалттай						
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэл т дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		94.0%	5	90.0	100.0	100.0	90.0	90.0
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ						

ТСР/MON/3703 “УУР АМЬСГАЛД УХААЛАГ ХАНДЛАГЫГ МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОГТОЛЦООНД ТУРШИН НЭВТРҮҮЛЭХҮЙ” ТЕХНИК, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ ЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

2021.02.26

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр	Уур амьсгалд ухаалаг мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцоог турших ТСР/MON/3703			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБ- ХХААБ			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	ХХААБ, ХХААХҮЯ 3 жил			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1: Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх эрхзүй, эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг уур амьсгалд ухаалаг хандлагуудтай уялдуулан сум, орон нутаг, үндэсний хэмжээнд мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөөнд тусгахад хувь нэмэр оруулах</p> <p>Зорилт 2: Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эдийн засгийн эргэлтийг уур амьсгалд ухаалаг хандлагаар нэмэгдүүлэх арга барилд малчдыг сургаж, чадавхижуулах</p> <p>Зорилт 3: Малын гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд тогтвортой нийлүүлэх түншлэлийг хөгжүүлэх, чадавхийг төслийн туршилтын малчдын бүлэгт бий болгох</p>			
5	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)	250.000 ам доллар		
		Үүнд:	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
		Нийт	250.000	172.228	69.0
		2020 онд	65.000	28,029.50	43.1
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ			
	<p>1-р зорилтын хүрээнд: Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх эрхзүй, эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг уур амьсгалд ухаалаг хандлагуудтай уялдуулан сум, орон нутаг, үндэсний хэмжээнд мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөөнд тусгахад хувь нэмэр оруулах,</p> <p>2-р зорилтын хүрээнд: Мал аж ахуйн үйлдвэрлэлийн эдийн засгийн эргэлтийг уур амьсгалд ухаалаг хандлагаар нэмэгдүүлэх арга барилд малчдыг сургаж, чадавхижуулах,</p>	<p>Бодлого, эрхзүйн 9 бичиг баримтанд явуулсан судалгаагаар салбар дундын зохицуулалт сул учраас уур амьсгалын өөрчлөлтийн талаар гаргасан бодлого, хөтөлбөр баримт бичиг мал аж ахуйн асуудлыг бүрэн тусгаагүй, МАА-ын талаарх баримт бичиг УАӨ-д дасан зохицох, даван туулах, эрчийг сааруулах шийдэл дутуу тусгагдсан гэж дүгнэсэн. ХШҮ-100%</p> <p>Хагас эрчимжсэн болон бэлчээрийн хивэгч мал бүхий (үхэр, хонь, ямаа) байгаль цаг уурын 3 ялгаатай бүсэд байрших 3 малчдын бүлгийг (Төв аймгийн Батсүмбэр, Дундговь аймгийн Луус, Хэнтий аймгийн Цэнхэрмандал) сонгож, нарны эрчим хүчээр ажиллах 3 худаг гаргасан. Худаг тус бүрийн дэргэд хуванцарыг дахин боловсруулсан, илжирч ялзрахгүй эдэлгээ урттай шон бүхий 2 га тэжээлийн ургамал тариалах талбайг бий болгож МААЭШХ-ийн судлаачид тэжээлийн олон наст царгас, нэг наст хошуу будааг тариалах агротехникийн сургалт, туршилтийг нутгийн малчдын оролцоотой явуулсан. Тариалсан хошуу будаагаар хүлэмжийн хийн ялгарал багатай дарш үйлдвэрлэх технологийн сургалтыг Батсүмбэр, Цэнхэрмандалын малчдын бүлэгт зохион байгуулсан. Харин Луус суманд 2019 оны зун их гантай</p>			

		байсан (7-р сарын сүүлээр ганцхан удаа бороо орсон) тул туршилтын 38 жижиг дэвсгэгэнд тэжээлийн таримал тариалах бичил туршилтын явуулж дэрст бэлчээрийг хашаалсан. ХШҮ-70%				
	3-р зорилтын хүрээнд: Малын гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд тогтвортой нийлүүлэх түншлэлийг хөгжүүлэх, чадавхийг төслийн туршилтын малчдын бүлэгт бий болгох	Туршилтын ажлын үр дүнд үндэслэн МААЭШХ-ийн судлаачид “Уур амьсгалд ухаалаг мал аж ахуй эрхлэхүй” малчдад зориулсан сургалтын 8 бүлэгт материалын эхний хувилбарыг боловсруулсан. 2020 онд Монгол эрдэмтдийн боловсруулсан энэ хувилбарыг НҮБ-ын ХХААБ-ын УАУМАА онлайн сургалтын модультай уялдуулан “Хивэгч малын маллагаанд уур амьсгалд ухаалаг хандлагыг нэвтрүүлэхүй” малчдад зориулсан сургалтын модулыг боловсруулж түүнийг НҮБ-ын 4 агентлаг, ХНХЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд бэлэн байх чадавхийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд Завхан аймгийн зорилтот 5 сумын малчдын хоршоодод сургагч багш бэлтгэхэд эхний байдлаар туршиж ашиглаад байна. Сургалтын модулийн эцсийн байдлаар бүрэн хянаж засварласан хувилбар 2021 оны 3-р сард бэлэн болно. ХШҮ-70%				
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	2020 оны төсвийн гүйцэтгэл 28.029.5 ам.доллар буюу 43.1 хувь байна Ковид-19 цар тахлын хорио цээрийн дэглэмийн улмаас арга хэмжээ тасалдсан. Малын тэжээл, ялгадасны дээжийг шинжлэх лабораторийн хүчин чадал хангалтгүй байгаа нь бодит үр дүн гарахад хүндрэлтэй байна. ЗӨВЛӨМЖ Төгсгөлийн тайланд 2019, 2020, 2021 онуудын арга хэмжээний төлөвлөгөө, хүрсэн үр дүнг, санхүүжилтын хамт тодорхой тусгаж дэлгэрэнгүй тайлан ирүүлэх, холбогдох материалыг хавсаргах Бодлого, эрхзүйн 9 бичиг баримтанд явуулсан судалгааны дүнг танилцуулах				
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төсөл хэрэгжүүлэгч, оролцогч талууд уялдаа холбоотой нягт хамтарч ажилласан байна.				
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		80%	3	100%	70%	70%
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				

**ЦАХИМ ХАА-Н ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХАД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТСР/MON/3704/C2 ТЕХНИК, ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ТӨСЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ ЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

2021.03.01

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	Цахим ХАА-н үндэсний стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлэх ТСР/MON/3704/C2			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБ ХХААБ			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААБ, ХХААХҮЯ Хэрэгжих нийт хугацаа: 2 жил			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1: Цахим ХАА-н үндэсний стратеги боловсруулна Зорилт 2: Хөдөө аж ахуйн үйлчилгээнд МХХТ-ын тэргүүлэх шийдлийг боловсруулан, туршин хэрэгжүүлнэ.			
5	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Төслийн болон удирдлагын зардалд 2020 оны жилийн эцсийн байдлаар 48,953 ам.доллар зарцуулж 84 хувийн биелэлттэйгээр санхүүжилтийг зарцуулсан байна.		
		Үүнд:	Төсөв (2019 он)	Гүйцэтгэл	
		Багц 1	58000	48,953	84%
		Багц 2 (г.м)			
		Нийт	58000	48,953	84%
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ			
	1-р зорилтын хүрээнд: Монгол Улсын цахим ХАА-н үндэсний стратегийн баримт бичгийг боловсруулна. Хүрэх үр дүн 1: Цахим ХАА-н үндэсний стратегийн баримт бичгийн боловсруулсан байна.	1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл – 100% Цахим ХАА-н үндэсний стратегийн баримт бичгийн төслийг НҮБ-ын ХХААБ, ОУ-н Цахилгаан Холбооны байгууллагын Ази Номхон Далайн бүсийн мэргэжилтэнүүдийн туслалцаатайгаар боловсруулж, төслийг ХХААХҮ Сайд, эрхэмсэг ноён Ч.Улаанд гардуулсан. Баримт бичгийг боловсруулахад 2 удаагийн зөвлөлдөх уулзалтыг холбогдох талуудын оролцоотойгоор хийж, салбарын тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон, мэдээлэл, харилцаа холбоо технологийн шийдэл ашиглан нэн тэргүүнд шийдвэрлэх боломжтой асуудлуудыг эрэмблэн, боломжит шийдлүүдийг дэвшүүлсэн.			
	2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 2: Хөдөө аж ахуйн үйлчилгээнд МХХТ-ын тэргүүлэх шийдлийг боловсруулан, туршин хэрэгжүүлнэ. Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.	2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл – 50% Тус зорилтын хүрээнд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг гаргах, тэргүүлэх ач холбогдолтой төсөл хөтөлбөрүүдийг нарийвчлах ажил, ач холбогдлын дараалал гаргах ажлыг ХХААХҮЯ-ны			

		бүтцэд шинээр байгуулагдсан Мэдээлэл технологи, статистикийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлж байна.			
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Ололт: ХХААХҮЯ Мэдээлэл технологи, статистикийн хэлтэс шинээр байгуулж, цахим хөдөө аж ахуйн стратегийг хэрэгжүүлэх чиглэлд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.</p> <p>Анхаарах асуудлууд: Цахим ХАА-н үндэсний стратегийн баримт бичгийн төслийг цаашид хянан эцэслэх, хэрэгжүүлэх зорилготой, олон талуудын оролцоо бүхий техникийн болон удирдах хороог ХХААХҮЯ-ны манлайлал дор байгуулан баримт бичгийг сайжруулах, тодотгох, батлах, хэрэгжүүлэх шаардлагатай.</p>			
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийн баримт бичгийг боловсруулах үйл ажиллагаанд ХХААХҮЯ-ны харьяа газрууд болох МЭЕГ, Малын удмын сангийн үндэсний төв, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв, Халх гол ХАА-н үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа, ХАА-н бирж болон засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд болох ХХМТГ, ХХЗХ, МХЕГ, УЦУОСМХ, ГЗБГЗЗГ, ЦУОШГ, ОБЕГ, Үндэсний статистикийн хороо, иргэний нийгмийн байгууллагуудаас Монголын хүнсчдийн холбоо, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудаас ХААИС, ШУТИС, хувийн хэвшлийн байгууллагуудаас ХАА-н давхар даатгал, Мобиком ХХК, Юнител ХХК идэвхитэй оролцон хамтран ажилласан.			
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
		75%	2	100%	50%
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ			
		75%			

**ХҮНСНИЙ ХЯНАЛТЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХАД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТСР/MON/3705 ТЕХНИК ТУСЛАЛЦААНЫ ТӨСЛИЙН 2020
ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН.**

2021.02.26

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл		
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	Хүнсний хяналтын удирдлагын тогтолцоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх ТСР/MON/3705		
2	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБ ХХААБ		
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААБ, ХХААХҮЯ Хэрэгжих нийт хугацаа: 2 жил 9 сар		
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ, ҮАБЗ		
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1: Аюулгүй, эрүүл хүнснээр хангагдах орчинг дэмжихийн тулд хууль, бодлогын баримт бичгийг сайжруулах, авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор Монгол Улсын хүнсний тогтолцоонд дүн шинжилгээ хийсэн байна.</p> <p>Зорилт 2: Нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл явцыг сайжруулахын тулд эрсдлийн үнэлгээ хийх, эрсдлийг мэдээлэх, хүнсний аюулгүй байдлын тандан судалгаа хийх тогтолцоо бэхэжсэн байна.</p> <p>Зорилт 3: Эрсдэлд суурилсан хүнсний хяналтын чадавхи бэхэжсэн байна</p> <p>Зорилт 4: Хэрэглэгчдийн хүнсний аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголт, дадал сайжирсан байна.</p>		
5	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)		
		Төслийн болон удирдлагын зардалд 2020 оны жилийн эцсийн байдлаар 78,777 ам.доллар зарцуулж 53 хувийн биелэлттэйгээр санхүүжилтийг зарцуулсан байна.		
	Үүнд:	Төсөв (2019 он)	Гүйцэтгэл	Хувь
	Багц 1	150,000	78,777	53%
	Багц 2 (г.м)			
	Нийт	150,000	78,777	53%
	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ		
	1-р зорилтын хүрээнд: Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх	1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл – 80%		
	Хүрэх үр дүн 1: Аюулгүй, эрүүл хүнснээр хангагдах орчинг дэмжихийн тулд хууль, бодлогын баримт бичгийг сайжруулах, авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор Монгол Улсын хүнсний тогтолцоонд дүн шинжилгээ хийсэн байна.	<ul style="list-style-type: none"> Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаар ахлуулсан ажлын хэсэгтэй хамтран Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийн бичиг баримтуудыг олон талуудын оролцоотойгоор нягтлан, хуулийн хэрэгжилтийн үнэлгээг i) хэрэгжилтийн явцад гарсан үр дүнг сайжруулах; ii) нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, тулгарч буй бэрхшээлүүд, эерэг болон сөрөг нөлөөллүүдийг тогтоох; iii) хэрэгжилтийг үр дүнтэй байлгахад анхаарах зүйлүүдийг тогтоох зорилгоор хийсэн. Түүнчлэн, Хүнсний салбарт хэрэгжиж байгаа Бодлого, Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн. 		

	2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 2: Нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл явцыг сайжруулахын тулд эрсдлийн үнэлгээ хийх, эрсдлийг мэдээлэх, хүнсний аюулгүй байдлын тандан судалгаа хийх тогтолцоо бэхэжсэн байна.		2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл – 20%				
	3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 3: Эрсдэлд суурилсан хүнсний хяналтын чадавхи бэхэжсэн байна		3-р зорилтын хүрээнд хэрэгж үүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл – 0% Энэ зорилтын биелэлтийг Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага хариуцдаг тул ХХААБ энэ талаар тайлагнахгүй.				
	4-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 4: Хэрэглэгчдийн хүнсний аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголт, дадал сайжирсан байна.		4-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл – 40% Олон нийтэд шим тэжээл-хүнсний аюулгүй байдал, хүнсний хаягдал, хуурамч хүнс болон махны үйлдвэрийн эрүүл ахуйн талаар зөв ойлголт, мэдээлэл өгөх сургалт сурталчилгааны материал бэлтгүүлэхээр Healthy diets- Good practices ТББ –тай гэрээ хийн ажиллаж 4 сэдвээр тус бүр 8-10 минутын видео хийсэн. Хэвлэл мэдээллийн сувгаар хүмүүст хүргэх, байгууллагуудад зохих хэбэрээр хүргүүлэх ажилыг 2021 оны 1-р улиралд дуусна.				
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)						
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ						
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
		53%	4	80%	20%		40%
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ					
		53%					

**МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА ХОЛБОО ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ, ИННОВАЦИЙН
ТУСЛАМЖТАЙГААР ХАА-Н ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮР АШИГ, МӨШГИХ
ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ТСР/MON/3706” ТЕХНИК ТУСЛАЛЦААНЫ
ТӨСЛИЙН 2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН.**

2021.02.26

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	МХХТ дэвшил, инновацийн тусламжтайгаар ХАА-н өртгийн сүлжээний үр ашиг, мөшгих тогтолцоог сайжруулах ТСР/MON/3706			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБ ХХААБ			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААБ, ХХААХҮЯ Хэрэгжих нийт хугацаа: 2 жил			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1: МАА-н салбарт ул мөрийг мөшгих тогтолцоог нэвтрүүлэх систем, аппликейшнг боловсруулах, турших Зорилт 2: МАА-н салбарын ул мөрийг мөшгих, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд МХХТ ашиглахад шаардагдах хууль тогтоомж, удирдамжтай байх Зорилт 3: Сонгогдсон хоёр өртгийн сүлжээнд мөшгих тогтолцоог нэвтрүүлэх туршилт хийх, технологийн дэвшил ашиглах үндэсний чадавхыг сайжруулах			
5	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Төслийн болон удирдлагын зардалд 2020 оны жилийн эцсийн байдлаар 110,008 ам.доллар зарцуулж 78 хувийн биелэлттэйгээр санхүүжилтийг зарцуулсан байна.		
		Үүнд:	Төсөв (... он)	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1	141,000	110,008	78%
		Багц 2 (г.м)			
	Нийт	141,000	110,008	78%	
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ			
	1-р зорилтын хүрээнд: МАА-н салбарт ул мөрийг мөшгих тогтолцоог нэвтрүүлэх систем, аппликейшнг боловсруулах, турших Хүрэх үр дүн 1: Мөшгих тогтолцооны процесс, систем, технологийг хөгжүүлэх, хязгаарлагдмал нөхцөлд турших	Мал, амьтны мөшгих тогтолцооны процесс, систем, технологийг хөгжүүлэх чиглэлд тодорхой алхам хийж туршилтын төслийг тодорхой хязгаарлагдмал нөхцөлд турших ажил хийгдсэн. Мал эмнэлгийн ерөнхий газар /МЭЕГ/ дээр хэрэгжиж буй Мал эмнэлгийн нэгдсэн систем (МЭНС)-ийн малын мөшгих тогтолцоо нь малчны хотоос махны үйлдвэр хүртэлх үйл ажиллагаанд хяналт тавьдаг байсныг цааш өргөжүүлж, махны үйлдвэр хүнсний захууд дээр махны чанарын хяналтын тогтолцоог хийх боломжтой байхаар системийг хөгжүүллээ. МЭЕГ дээр хэрэгжүүлэлтийн түвшинд явж байна. Тус мөрдөн мөшгих тогтолцоог блокчейн суурьтай болгох ажлыг гүйцэтгэж буй бөгөөд нэвтрүүлэлтийн түвшинд байна. Тус мөшгих тогтолцоог блокчейн суурьтай болгох нь системийн найдвартай байдлыг үнэмлэхүй өндөр түвшинд хүргэж, өндөр хөгжсөн зах зээлийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж, махны экспортыг нэмэгдүүлэх боломж бүрдүүлнэ.			

	<p>2-р зорилтын хүрээнд: МАА-н салбарын ул мөрийг мөшгих, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд МХХТ ашиглахад шаардагдах хууль тогтоомж, удирдамжтай байх</p> <p>Хүрэх үр дүн 1: мөшгих тогтолцоо болон малын гаралтай бүтээгдэхүүний үнэ цэнийн хэлхээг хөгжүүлэх чиглэлд шаардлагатай хууль эрх зүйн болон дүрэм журмын өөрчлөлт хийх</p>	<p>МУ-ын махны үйлдвэрийн стандарт ажиллагааны стандарт ажиллагааны зааврыг /САЗ/ МЭЕГ-аар батлуулсан. Махны үйлдвэрийн үйл ажиллагааны систем нь МЭЕГ-аас махны үйлдвэрүүд болон хүнсний захууд дээр мах боловсруулах үйл ажиллагаанд чанар, эрүүл ахуйн хяналт тавих боломжийг нэмэгдүүлж байгаа бөгөөд махны үйлдвэрийн САЗ-ын дагуу хөгжүүлэгдсэн. Энэ нь цахим засгийн мастер төлөвлөгөөнд туссан зорилттой нийцэж байгаа бөгөөд эцсийн хэрэглэгчийн түвшинд мах, махан бүтээгдэхүүний гарал үүслийг шалгах, нягтлах бололцоог бүрэн хангана.</p>				
	<p>3-р зорилтын хүрээнд: Сонгогдсон хоёр өртгийн сүлжээнд мөшгих тогтолцоог нэвтрүүлэх туршилт хийх, технологийн дэвшил ашиглах үндэсний чадавхыг сайжруулах</p> <p>Хүрэх үр дүн 1: МХХТ ололт амжилтыг үндэсний хэмжээнд таниулах, тус салбарын хүний нөөцийг хөгжүүлэх</p>	<p>Үндэсний хэмжээний семинар зохион байгуулахаар төлөвлөгдсөн бөгөөд одоогийн байдлаар баруун болон төвийн бүсийн махны үйлдвэрийн технологичдыг сургалтад хамруулсан. Үндэсний хэмжээний семинар зохион байгуулах ажил нь Ковид-19-ийн нөхцөл байдлаас шалтгаалан хойшилж, 2021 оны эхний хагаст багтаан зохион байгуулахаар хүлээгдэж байна.</p> <p>“Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологи, мал эмнэлэг ариун цэврийн нөхцөл” сэдэвт хангайн болон баруун бүсийн сургалтыг зохион байгуулж, хангайн бүсийн сургалтад 54, баруун бүсийн сургалтад 45 хүн тус тус хамрагдсан. Сургалтад тус бүс нутгийн 9 аймагт үйл ажиллагаа явуулж буй мал төхөөрөх үйлдвэр, цехийн малын эмч, технологич, улсын байцаагч хамрагдсан.</p>				
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<ol style="list-style-type: none"> 1. Төслийн үйл ажиллагаа Ковид - 19 цар тахлын нөлөөнөөс шалтгаалан хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна. 2. Өмнө нь хөгжүүлсэн, ашиглалт сайтай байгаа Мал эмнэлгийн нэгдсэн системийн нэг хэсэг байдлаар системийг хөгжүүлсэн нь ололттой байна. 3. Мал эмнэлгийн ерөнхий газарт тус системийг хүлээлгэн өгсөн гэж тайлагнасан боловч МЭЕГ-ын ХЭУГ-ын дарга тус системийн талаар мэдээлэлгүй байгаа тул мэдээллийг холбогдох хүмүүст бүрэн хүргэх чиглэлд сайтар анхаарах шаардлагатай байна. <p>Зөвлөмж.</p> <ol style="list-style-type: none"> 1. Тус системийн талаарх мэдээллийг холбогдох хүмүүст бүрэн хүргэх чиглэлд сайтар анхаарах, 2. Төслийн үлдсэн хугацаанд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх, 				
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ.				
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		73.3%	3	70.0	100.0	50.0
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		73.3%				

**ТСР/MON/3707 “МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХЭД
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ” ТЕХНИК, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСЛИЙН
2020 ОНЫ ҮЙЛ ЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

2021.02.26

№	Төслийн агуулга		Гүйцэтгэл		
1	Төсөл, хөтөлбөрийн нэр		Малын генетик нөөцийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх ТСР/MON/3707		
2	Санхүүжилтийн эх үүсвэр		НҮБ-ХХААБ		
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих хугацаа		Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ- ХХААБ		
			2019.08-2021.07		
4	Төслийн хамрах хүрээ		21 аймаг, нийслэлийн 331 сум, 6 дүүргийн нийт мал сүрэг		
5	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Зорилт 1: Малын генетик нөөцийн үнэлгээ хийх, үүлдэр, омгийн малын тоо, толгойг тогтмол хянах, баталгаажуулах нөхцлийг бүрдүүлэх. Зорилт 2: Мал аж ахуйн салбарын төлөвлөлт, бодлогыг тодорхойлоход төрөл бүрийн үүлдэр, омгийн малын популяцийн бодит тоо баримтыг бүрдүүлэх.		
6	Зардал	Төсөв	165.000 ам доллар		
		Зарцуулалт	Төсөв	Гүйцэтгэл	Хувь
		Нийт	165.000	113,637	69.0
		2020 онд	90.000	74.704	83.0
7	Хөтөлбөрийн зорилт :		Биелэлт		
	Бүрэлдэхүүн хэсэг-1 Малын генетик нөөцийн үнэлгээ хийх, үүлдэр, омгийн малын тоо, толгойг тогтмол хянах, баталгаажуулах нөхцлийг бүрдүүлэх.		- Малд үзлэг, ангилалт хийхэд шаардлагатай 3 төрлийн зоо-багаж /туузан метр, палкметр, бог малын жин/ худалдан авах тендэрт Голланд Улсын Graidsco B.V компани шалгарч ISO стандарттай 3 төрлийн зоо багажийг нийлүүлсэн хэдий ч ХХААХҮ-ийн ТНБД-ын тушаалаар томилогдсон бараа хүлээн авах ажлын хэсэг хүлээн авах боломжгүй гэж дүгнэж НҮБ-ын ХХААБ-д албан бичгээр мэдэгдсэн. ХШҮ-70%		
			- Монгол улсын баталгаажсан үүлдэр омгийн зураг, тайлбарт цомог, “Үүлдэр таних өврийн дэвтэр”-ийн хэвлэлийн эх бэлтгэл удаашралтай. ХШҮ-30%		
	Бүрэлдэхүүн хэсэг-2 Мал аж ахуйн салбарын төлөвлөлт, бодлогыг тодорхойлоход төрөл бүрийн үүлдэр, омгийн малын популяцийн бодит тоо баримтыг бүрдүүлэх.		- Монгол Улсад өсгөн үржүүлж байгаа малын генетикийн олон янз байдал, популяцийн үүлдэрлэг байдал, тоо, газар зүйн тархалтын хувьсал, өөрчлөлт, малын генетик нөөц ашиглалт, түүний эдийн засгийн үр өгөөж, цаашдын хандлагыг бүс нутаг, аймаг, сум, дүүрэг тус бүрээр гаргаж, улсын хэмжээнд нэгтгэсэн Үндэсний тайлангийн төслийг Малын генетик нөөцийн үндэсний зөвлөл (МГНҮЗ), ХХААХҮ-ийн с		

		<p>айдын зөвлөлд танилцуулахад бэлэн болсон.</p> <p>Үндэсний тайлан дараахь 6 бүлэгтэй:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын малын генетикийн олон янз байдал, тэдгээрийн хувьсал өөрчлөлт - Малын генетик нөөцийн ашиглалтын төлөв байдал, ач холбогдол - Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдал, цаашдын хандлага - Монгол Улсын мал сүргийн генетик сайжруулалтын стратеги - Малын генетик нөөцийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын төлөв байдал, чиг хандлага <p style="text-align: right;">ХШҮ-100%</p> <ul style="list-style-type: none"> - 2020 онд “Буган халиун” үүлдрийн хэсгийн үхэр, “Бүрэгхангай” үржлийн хэсгийн хонийг Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлийн хурлаар, Баянбулаг омгийн хонь, Олдохын хүрэн бор омгийн тэмээг ХХААХҮСайдын тушаалаар тус тус батлуулж МУ-ын хэмжээнд баталгаажсан үүлдэр, омгийн мал 54 болж өслөө. Үүнээс DAD-IS системд 52 үүлдэр, омгийн малын мэдээллийг бүрэн шинэчилж оруулсан. <p style="text-align: right;">ХШҮ-100%</p>
8	<p>ДҮГНЭЛТ</p> <p>(ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<ul style="list-style-type: none"> - 2020 оны төсвийн гүйцэтгэл 74.704 ам.доллар буюу 83.0 хувь байна - Малын генетик нөөцийн төлөв байдлын үндэсний тайланг боловсруулсан. Тайланг МГНҮЗХороо, ХХААХҮСайдын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхэд бэлэн болсон. - 21 аймгийн 331 сум, нийслэлийн мал бүхий 6 дүүргийн хөдөө аж ахуйн тасагт нийлүүлэх зоо багаж, хэрэгслийг ХХААХҮ-ийн ТНБД-ын тушаалаар томилогдсон бараа хүлээн авах ажлын хэсэг хүлээж авах боломжгүй, зоо багаж шаардлага хангахгүй гэсэн дүгнэлтийг гаргасан. <p>ЗӨВЛӨМЖ</p> <ul style="list-style-type: none"> - Төгсгөлийн тайланд 2019, 2020, 2021 онуудын арга хэмжээний төлөвлөгөө, хүрсэн үр дүнг, санхүүжилтын хамт тодорхойтусгаж дэлгэрэнгүй тайлан ирүүлэх, холбогдох материалыг хавсаргах - I улиралд багтаан Малын генетик нөөцийн төлөв байдлын үндэсний тайланг Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хорооны хурлаар хэлэлцүүлэх - II улирлын эхний хагаст багтаан ХХААХҮСайдын зөвлөлд танилцуулан, Монгол, Англи хэл дээр хэвлүүлэх ажлыг зохион байгуулах - Чанар, стандартын шаардлага хангасан зоо багаж нийлүүлэх ажлыг зохион байгуулах - Монгол улсын баталгаажсан үүлдэр омгийн зураг, тайлбарт цомог, “Үүлдэр таних өврийн дэвтэр”-ийн хэвлэлийн эх бэлтгэлийг яаралтай боловсруулж, хэвлүүлэх, орон нутагт хүргүүлэх ажлыг зохион байгуулах

9	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	- Төсөл хэрэгжүүлэгч, оролцогч талууд уялдаа холбоотой нягт хамтарч ажилласан байна.			
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Жилийн хэрэгжилт	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
	Тухайн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ	75%	2	50%	100%
11	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ			
	(ЗГХЭГ-ын үнэлгээ)				

**КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ХҮНСНИЙ БАТАЛГААТ БАЙДАЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ТСР/MON/3801/C1 ТЕХНИК,
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨСЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ ЖИЛЛАГААНЫ
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

2021.02.26

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	КОВИД-19 цар тахлын хүнсний баталгаат байдалд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ТСР/MON/3801/C1			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	НҮБ ХХААБ			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААБ, ХХААХҮЯ Хэрэгжих нийт хугацаа: 8 сар			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1: Зарим нэр төрлийн (лууван, манжин, хүрэн манжин, улаан лооль, өргөст хэмх) хүнсний ногооны үрээр нийт 1430 тариаланчидыг хангана. Зорилт 2: Хүнсний ногоо тариалагчдын технологийн мэдлэг, чадварыг сайжруулна.			
5	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Төслийн болон удирдлагын зардалд 2020 оны жилийн эцсийн байдлаар 61,405 ам.доллар зарцуулж 99 хувийн биелэлтгэтэйгээр санхүүжилтийг зарцуулсан байна.		
		Үүнд:	Төсөв (... он)	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1	62,000	61,405	99%
		Багц 2 (г.м)			
	Нийт	62,000	61,405	99%	
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ			
	1-р зорилтын хүрээнд: Зарим нэр төрлийн (лууван, манжин, хүрэн манжин, улаан лооль, өргөст хэмх) хүнсний ногооны үрээр нийт 1430 тариаланчидыг хангана. Хүрэх үр дүн 1: Хүнсний ногооны үрээр хангаж, хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл - 111.3 сая төгрөгийн 9 нэр төрлийн 3375.6 кг хүнсний ногооны үрийг буцалтгүй тусламжаар олгосон. Лууван, шар манжин, хүрэн манжин, сармис, ногоон болон бөөрөнхий сонгино, өргөст хэмх, улаан лооль, амтат чинжүү зэрэг нийт 9 нэр төрлийн хүсний ногооны үрээр хангасан. - 21 аймаг, 293 сум, нийслэлийн 9 дүүргийн 194 аж ахуйн нэгж, хоршоо, 4061 өрх 558.4 га-д 9 нэр төрлийн ногоо тариалж 6161.08 тн ургац хураан авсан. - Өрхийн орлогыг хураан авсан ургацын зах зээлийн дунджаар тооцвол 550-750 мянган төгрөгийн бодит тусламж болж очсон байна.			
	2-р зорилтын хүрээнд: Хүнсний ногоо тариалагчдын технологийн мэдлэг, чадварыг сайжруулна. Хүрэх үр дүн 1: Ногоо тариалах технологийн сургалт, арга зүйгээр хангана.	2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл - Тариалангийн улиралын үед аймгийн болон сумдын агрономчид тариалангийн талбайд ажиллан тариаланчдад мэргэжлийн зөвлөгөө өгсөн. - Хэнтий аймгийн Мөрөн сумын тариаланчдын тоног төхөөрөмжийн хангалтгүй байдлыг харгалзан 13 морины хүчин чадал бүхий гар трактороор хангасан.			

		<ul style="list-style-type: none"> - Үрийг хувиарлан тараах, тариалах, ургац хураах үеүүдэд хяналт хийсэн. - Хөдөө аж ахуйн бүтээмжийн төвтэй ажил гүйцэтгэх гэрээ хийж “Ногоо тариалах технологийн сургалт”-ыг нийт 50 тариаланчид, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн Эдийн засгийн хүрээлэнтэй ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд ХАА-н марктенгийн сургалтуудыг нийт 28 тариаланчдын дунд зохион байгуулсан. Сургалтад Дорнод, Төв, Хөвсгөл, Сэлэнгэ, Ховд, Дархан-Уул зэрэг аймгийн тариаланчид оролцсон. 			
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<ul style="list-style-type: none"> - НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас КОВИД-19 цар тахлын хүнсний баталгаат байдалд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ТСР/MON/3801/C1 төслийг хэрэгжүүлж, хүнсний ногооны тариалан эрхэлдэг 21 аймгийн 293 сум, нийслэлийн 9 дүүргийн 194 аж ахуйн нэгж хоршоо, 4061 өрхийг тариалан эрхлэхэд нь зориулж 111.3 сая төгрөгийн үнэ бүхий 9 нэр төрлийн 3375.6 кг хүнсний ногооны үр олгосон нь цаг үеэ олсон үр дүнтэй ажил болсон байна. 			
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ				
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
		100%	2	100%	100%
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ			